

**Удирдах ажилтнуудын 06 дугаар сарын 27-ны өдрийн  
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2022 оны 07 дугаар сарын 20

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
1.	Аймгийн Засаг дарга, орлогч даргын оролцох 07 дугаар сарын үйл ажиллагаа, арга хэмжээний мэдээллээ ТЗУХ-т ирүүлэх.	2022.07.01-ний дотор	Бүх байгууллага	Аймгийн Засаг дарга, орлогч даргын 07 дугаар сард оролцох үйл ажиллагааны мэдээллийг нийт 35 байгууллага ирүүлсэн байна. Үүнээс аймгийн Засаг дарга, орлогч дарга нар оролцох 5 үйл ажиллагаа байна. Үүнд: 1. Гамшгаас хамгаалах албадын үерийн гамшиг тохиолдсон үед ажиллах бэлтгэл бэлэн байдлын үзлэг. 2. “Аюулгүй жишиг хороолол” төслийн хаалтын үйл ажиллагаа. 3. Цагдаагийн хэлтэс: 07 дугаар сарын 14-19-ний өдрүүдэд Цагдаагийн байгууллагын түүхт 101, Дотоодын цэргийн 100 жилийн ойн тэмдэглэлт баяр 4. Аймгийн баяр наадам	100
2.	Удирдах ажилтны цахим хуудсанд цаг үеийн мэдээллээ оруулах	7 хоног бүрийн Баасан гарагт	Сумдын Засаг дарга	Удирдах ажилтны фэйсбүүк групп хаягт цаг үеийн мэдээллээ Сүмбэр сум, Шивээговь сум оруулсан байна.	66.6
3.	Баяр наадмын үйл ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулах	2022.07.02-11	Сумдын Засаг дарга	Шивээговь сумын баяр наадам 07 дугаар сарын 02, 03-ны өдөр Баянтал сумын баяр наадам 07 дугаар сарын 07, 08-ны өдөр Аймгийн баяр наадам 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Мөн 07 дугаар сарын 09-ний өдөр Хүндэтгэлийн хурал, концерт, 07 дугаар дугаар сарын 10-ны нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны А/183 дугаар захирамжаар томилогдсон Баяр наадам зохион байгуулах комисс салбар комиссууд бэлтгэл ажлыг ханган ажилласан. Баяр наадмаар нийт 128 бөх, өсвөрийн 32 бөх барилдаж, 6 насны 239 морь уралдаж, үндэсний шагай харваанд-3 аймгийн 7 сумын 13 багийн 104 харваач, үндэсний сурын харваад 7 аймгийн 108 харваач баг тамирчид баяр наадмын үйл ажиллагаанд оролцсон байна. Баяр наадмаар 26 хүнийг төрийн дээд одон медаль, 270 хүнийг ардын хувьсгалын 100 жилийн одон медалиар шагнасан байна.	100
<b>Нийт</b>					<b>88.8</b>

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**